# БАРУУН-УРТ СУМЫН 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Тайлант сарын байдлаар Тамгын газраас 111 бичиг явж, 169 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-17, хугацаандаа явсан-4, хугацаа болоогүй-3 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тус Тамгын газар нь албан хэргээ хос бичгээр хөтөлж хэвшсэн.

Байгууллагын даргаас гаргасан шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчилгүй шийдвэр гаргаж хэвшсэн. “Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 40 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 464 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

ҮНТ-ийн офератороос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт-20, иргэний үнэмлэхний лавлагаа-13, оршин суугаа хаягийн бүртгэл-12, үл хөдлөх хөрөнгөтэй эсэх-6, төрсний гэрчилгээ-5, жолоочийн лавлагаа-5, шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх-4, эд хөрөнгийн улсаын бүртгэлийн лавлагаа-5, жолооны үнэмлэх захилга-3, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх-3, үл хөдлөх хөрөнгө жагсаалтаар 2, гэрлэлт бүртгэлгүй эсэх лавлагаа-2, авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй эсэх -2, гэрлэсэний бүртгэлийн лавлагаа-1, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх-1, боловсролын гэрчилгээ-1, төлбөртэй үйлчилгээ-12, төлбөргүй үйлчилгээ-73, портал системээр нийт 84 төрлийн үйлчилгээ үзүүлсэн.

**Нийгмийн хамгааллын чиглэлээр:**Сумын Засаг даргын Тамгын газраас ”Найрсаг Баруун-Урт” хөдөөгийн 8 дугаар багийн өдөрлөгийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2023 оны 08 дугаар сарын 11-14-ний өдрүүдөд Шаргын говь, Их булаг, Хоньт, Ханан зэрэг газруудад зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар явуулын амбулаторийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Үзлэгт нийт 500 гаруй иргэн хамрагдснаас ....өвчлөл илрүүлж, эмчилгээ заан, зөвлөгөө өгч, дараагийн шатлалд илгээлээ. Мөн төрийн байгууллагуудтай 350 гаруй иргэнд төрийн үйлчилгээний талаар мэдээ мэдээлэл хүргэж, гарын авлага тараасан.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, Энхлэн ачтан өрхийн эрүүл мэндийн төв, сургуулийн өмнөх боловсролын 1,2 дугаар цэцэрлэг хамтран уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан эмийн бус аргаар бага насны хүүхдийг чийрэгжүүлэн, суурь болон цочмог өвчлөл, эрдэс амин дэмийн дутагдлыг бууруулах зорилгоор хүүхдийн “Нархан сувиллыг агро паркийг түшиглэн ажиллуулсан. Сувилалд аймгийн нэгдсэн эмнэлэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс ирсэн зорилтот хүүхдүүд, хувилбарт цэцэрлгэийн болон томуу томуу төст өвчнөөр давтан өвчилсөн, дархлаа суларсан 2-5 насны нийт 150 хүүхдийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд 3 ээлжээр хамруулж, өдрийн 5 удаагийн эмчилгээний хоол, бүтэн биений бариа, сүүн бариа, ясны шөл, шар сүү, хар цайнд оруулж, бумба тавих эмчилгээнүүдийг хийлээ. Мөн тус сувилалд нийт 23 албан хаагч ажилласан бөгөөд албан хаагч тум бүрд ажилласан хоногийн тоогоор үндсэн цалинг олгосон.

Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд БНСУ-ын Тэгү хот дахь Эрүүл мэндийн сэргээн засах судалгааны хүрээлэнд болох сургалтанд Энхлэн ачтан Өрхийн эрүүл мэндийн төвийн уламжлалын их эмч Э.Пүрэвсүрэн, сэргээн засахын сувилагч Г.Эрдэнэтуяа нарт тус бүр 1,0 сая төгрөг нийт 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Ззасаг даргын нөөц сангаас олгосон. Манжуур хотод болох Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоноос жил бүр зохион байгуулдаг говь болон зүүн бүсийн аймгуудын Өрхийн эмч мэргэжилтнүүдийн мэргэжил хандлага, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох уулзалтад 15 эмчийг хамруулсан.

**ХАА-н чиглэлээр**:Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн А/227 тоот захирамжаар цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины ажлын хэсэг нийт-22 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй гарч ажиллаж байна. Сумын хэмжээнд хурга-100 толгой малыг цэцэг өвчний дархлаажуулалтад хамруулахаар Мал эмнэлгийн газраас цэцгийн вакцин-100.0 мян/тун хүлээн авч, 6 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгсөн.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын явцын мэдээгээр өрх-129, хурга-17512 толгой малд вакцин хийгдэж байна.

Төл малыг бруцеллёз өвчнөөс урьдчилан вакцин Штам-19,10.5 мян/тун, Рев-1,126.2 мян/тун вакцин болон галзуугийн вакцин-11,0 мян/тун авч, ДХХ -энтериобактериоз хам вакцин-231.0 л авч, МЭГазраас татан авч, 6 мал эмнэлэгт хуваариалан өгч ажилласан.

Дуут хавдрын вакцин-47.4 л авч, үхэр-3055 толгой малд, листериозийн вакцин-140 л авч, хонь-13300, ямаа-5143 нийт-18443 толгой малд, цусан халдвартын вакцин-290.4л авч, хонь-7744, ямаа-5173 нийт-12917 толгой малд, бүгд-34415 толгой малд төлөвлөгөөт орон нутгийн вакцинжуулалтыг хийн гүйцэтгэж байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд: Угаалганд үхэр-995, хонь-17029, ямаа-9805 нийт-27829, туулгалтад хонь-8525, ямаа-6532 адуу-120, нийт-15177, боловсруулалтад хонь-12439, ямаа-5857, гуурын боловсруулалтад үхэр-1200 нийт-19496, бүгд-62502 толгой мал хамрагдаад байна.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 2023 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн сумын Засаг даргын А/ 118 тоот захирамжийн дагуу 4-н групп, гарч 04 дүгээр сарын 26 -наас 07 дүгээр сарын 30-ны хүртэл малын эмч, туслах ажилчин, жолооч, 12-н хүний бүрэлдэхүүнтэй тарилгыг хийж гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн газраас цэцгийн вакцин-43631мян/тун хүлээн авч, ААН-ийн 4 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгч ажилласан.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хот айл- 99, хонь-35729 хурга-9784, нийт- 45513 толгой малд тарилгыг хийж ажиллалаа.

Тарилгын зарцуулалтад вакцин-43513мт, хэвийн хорогдол-118, зарцуулан-43513 л, хонь-35729, хурга-9784, нийт- 45513 толгой малд вакциныг хийж гүйцэтгэн нэгтгэн МЭГазарт өгч ажилласан.

Малын эмч нараас тарилгын хоосон шил- 97ш, хүлээн авч МЭГазарт тушаан, өгч ажилласан. Вакцинжуулалтын явцын мэдээ болон шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга, туулгалт, боловсруулалтын мэдээ, судалгааг Мал эмнэлгийн газарт өдөр бүр өгч ажиллалаа.

Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтад нийт-30 малчин өрхөөс судалгааг авч, ажилласан.

Амьд мал, махны гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулан ажиллаж байна.

**Санхүүгийн чиглэлээр**:Иргэн 9, байгууллага 14 нийт 116,110.3 сая төгрөгийн албан бичиг ирснийг бүрэн шийдвэрлэж ажилласан. /Төсвийн тодотголтой холбоотой 115,630.3 мянган төгрөг, УТХ буцаалт 480.0 мянган төгрөг/

Харъяа 8 төсөвт байгууллага нь дулааны тоолуурыг суурилуулж нийт 64,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Жилийн эцсийн аж нэгжийн тайлангаа илгээгээгүй 32 аж нэгж байгууллагын 25 байгууллагад нь хуулийн хугацаанд тайлангаа хүргүүлж байх талаар зөвлөмж өгсөн.

ОНХСан, Сум хөгжүүлэх сангийн 376,983.8 мянган төгрөгийн /5 ш/ гүйлгээг цахимаар хийж, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж банйа.

8 дугаар  сард 18 төсөвт байгууллага, 3 ОНӨААТҮГ, 2 сангийн 1,311,963.6 мянган төгрөгийн /202 ш/ гүйлгээг цахимаар хянан баталгаажууллаа.

Харъяа 18 төсөвт байгууллага 3 ОНӨААТҮГазар уудад нийт 4,250,164.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, санхүүгийн үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна

8 дугаар сарын байдлаар 4,744,896.7 мянган төгрөг орлго орж, орлогын төлөвлөгөө 103.7 хувьтай байна.

Сумын 2024 оны төсвийн төсөөлөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж Аймгийн СТСХэлтэсийн төсвийн мэргэжилтэнд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Харъяа төсөвт байгууллагуудын 377 төлбөрийн хүсэлт ирснээс баталгаажсан гүйлгээний тоо- 355, залруулсан болон алдаатай гүйлгээний тоо-22 нийт 1800418120.19 төгрөгийн гүйлгээ баталгаажуулсан байна. Хавсралт материал дутуу шаардлага хангаагүй, хамааралгүй баримт хавсарсан болон системийн алдаанаас шалтгаалан буцаагдсан гүйлгээнүүдийг тухай бүрт буцаан алдааг засварлуулж гүйцэтгүүлэн ажиллалаа.

**Хот тохижилт, газар зохион байгуулалтын чиглэлээр**:Иргэдийн аюулгүй, тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 9 дүгээр багт камержуулалт байршуулах ажлын тендерт аймгийн төсвөөс 20,0 сая төгрөг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 105,0 сая төгрөг батлагдсаны дагуу tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулж тендерт 6 компани оролцсон. Тендерт Топика ХХК 124,271.3 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 9-р баг дээр нийт 24 ширхэг камер суурилуулах ажил хийгдэнэ. Үүнд: 15 байршилд нүүр таньдаг 2, дугаар таньдаг 2, энгийн 20 камер/ уг ажил гэр хороололд анх хэрэгжиж байгаараа онцлог юм. Багийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа камержуулалтын ажлын явцтай танилцлаа. Нийт 15 байршилд энгийн 20 камер , тусгай зориулалтын 4 камер /

дугаар таньдаг 2ш, царай таньдаг 2ш/ мөн зориулалтын 4 шон суулгахаас тусгай зориулалтын 4 камераас бусад байршил дээр хийгдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн 398.902.383 төгрөгийн хөрөнгөөр худалдааны гудамжны тохижилтийн ажлыг “Жавхланхүслэн” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын явцтай танилцаж тухай бүр тулгамдаж буй асуудлыг холбогдох газруудад уламжилж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

**7 сарын 4-ны өдөр эхэлсэн**



**7 сарын 7**



**7 сарын 17**



**7 сарын 25**



**8 сарын 14**



**8 сарын 24**



**Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт /9 баг/ - 124.271.300 төг - Топика ХХК**

9 дүгээр багийн нийтийн эзэмшлийн камержуулалт байршуулах тендерт шалгарсан Топика ХХК нийт 24 ширхэг камер суурилуулах ажил хийгдэнэ. Үүнд: 15 байршилд нүүр таньдаг 2, дугаар таньдаг 2, энгийн 20 камер/ Уг ажил гэр хороололд анх хэрэгжиж байгаараа онцлог юм. Энгийн 20 камер суурилагдсан. Царай болон машины дугаар таньдаг камерын суурь нь хийгдэж байна.





**Тоглоомын талбайн засвар, шинэчлэл /1 р баг, Тэжээл/ - ОНХС – 56.150.600 – Талын баян эрхэт ХХК** Уг ажлын хүрээнд бетонон талбайн тэгшилгээ, явган зам, тоглоомын талбай, сагсны талбай, элсний талбайн ажлууд тус тус хийгдэнэ. Тус ажлуудаас бетонон талбайн тэгшилгээ, элсний талбайн ажил хийгдсэн.

**8 сарын 15**



**8 сарын 17**



**8сарын 24**



Их хэмжээний усархаг борооны улмаас усны үерт өртсөн айл өрхүүдтэй холбоотой асуудлаар газар дээр нь очиж тодруулга авч, хүнсний дэлгүүр аж ахуй нэгжүүдтэй уулзан гадна талбайн тохижилт болон бусад асуудлаар санал зөвлөмж хүргэж, хатуу хучилттай зам дагуух унасан хашааг босгуулах ажлыг гүйцэтгэж байна.





9 дүгээр багт байрлах зөөврийн усан сан нь их хэмжээний усархаг бороо орсоны улмаас урд талын засмал замд ус зайлуулах хоолой байхгүйн улмаас ус тогтож усан сангийн тоног төхөөрөмжүүд шатаж эвдэрсэн. Уг ажилтай холбоотой асуудлаар Дөрвөлж компанид хамтран ажиллах албан бичиг өгч, ус их тогтож байгаа хэсгийн ус зайлуулах шугам /Лотки/ байршуулах хэмжилт хийж ажилсан.





СҮХБААТАР АЙМГИЙН
БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

ДӨРВӨЛЖ ОНӨААТҮГАЗАРТ

Тус сумын 9 дүгээр багт байрлах зөөврийн усан сан 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр танай байгууллагын ажлын хэсэг хүлээн авсан билээ.

Иймд хүлээн авсан хугацаанаас хойш ... усан сангийн эвдрэл гэмтлийг засварлаж, ... ус түгээх ажлыг эрчимжүүлж хамтран ажиллана уу.

Хавсралтаар холбогдох материалуудыг хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Э.ХҮРЭЛЧУЛУУН

СҮХБААТАР АЙМГИЙН
БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДӨРВӨЛЖ ОНӨААТҮГАЗАРТ

2022 оны орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар усны машины оролцоо 30,000,000 /гучин сая / төгрөг, усан сан байгуулах ажилд 37,496,900/ гучин долоон сая дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун/ төгрөг нийт 67,496,900 / жаран долоон сая дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун / төгрөгийн ажил хийгдсэн тул данс бүртгэлдээ тусгаж авна уу.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.САРАНГЭРЭЛ

Аймгийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар сумын төвийн хатуу хучилттай авто зам сэтлэх, орц, гарц, зогсоолын талбай гаргах зөвшөөрөл олгох ажлыг хууль, тогтоомжийн хүрээнд хариуцан зохион байгуулахыг Баруун-Урт сумын Засаг даргад даалгасан.

ҮТП-ын гүүрэн самбараас баруун 4 замын уулзвар хүртэлх автозамын гэрэлтүүлгийн 20ш толгой солих ажил хийгдсэн.





Төв замын гэрэлтүүлгийн гэмтлийг олж тогтоож холболт хийж, ил гарсан утсыг далдалж булах ажил хийгдлээ. Үүнд.






Асгатын зам дагуу







3-р тойргийн зам дагуу




Жигжиджавын садны зүүн талаас урагш 4 зам хүртэлх





Дөрвөлж толгой Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн





Нийт 1,2,3-р багийн 5 авто замын гэрэлтүүлгийн гэмлийг олж тогтоон холболт хийж, утас далдлах булах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Цаг үетэй холбогдуулан аймгийн хэмжээнд асч байгаа авто замын болон цамхагт гэрэлтүүлгийн цагийн зохицуулалтыг хийж, асалт, унтралтыг 8:40-01:00 хүртэл хугацаанд асааж, унтрааж байхаар тохируулга хийгдлээ.





3-р тойргийн зам, төв зам, Төмөртэйн замд нийт 34 шонгийн тэгшилгээ хийгдлээ.

Баруун-гүүрний 2 талын гэрэлтүүлгийг сэргээн засварлах ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ.






**Орцны гэрэлтүүлгийн  засварын ажлын хүрээнд:**

Нийтийн эзэмшлийн орон сууцны орцны гэрэлтүүлгийг сольж, засврлах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:Жаргалан хотхон 27А байрны 2-р орцны 3 давхарт 1ш мэдрэгчтэй гэрэл, Мандал хотхоны 180 айлын орон сууцны 3-р байрны орцны гэрэлтүүлэг нийтээрээ асахгүй болсон шийтний цахилгааны холболтыг хийж, гэрэлтүүлэгийг асаалаа.






Ногоон хотхоны 100-р байрны нүүрэн тал, 103-р байрны баруун талд ус зайлуулагч агааржуулалтын хоолой угсрах ажил хийгдсэн. Засварын зардалд нийт 100ф хоолой  8ш, хананд холбох хэрэгсэл, шулжүүлэг 4ш зэрэг материал зарцуулагдлаа.





Одкон хотхоны 1, 3-р байранд ус зайлуулагч хоолой 2ш, 38 айлын орон сууцанд 1ш ус зайлуулагч агааржуцулалтын хоолой хийж гүйцэтгэлээ.

Жаргалан хотхон Дөрвөлж-12 айлын орон сууцны бохирын усны шугам хагарч, гэмтэл гарсаныг Дөрвөлж Компани засварчидтай хамран шаардлагатай материалаар ханган засах, солих ажил хийгдлээ.





Ногоон хотхоны 100-р байрны подвальд их хэмжээний борооны ус орж, тогтсон усыг фомфоор соруулах, малтаж шавхаж асгах ажлыг хийж гүйцэтгэж ариутгах ажлыг хийж гүйцэтгэлээ.





Мандал хотхоны 1-р байрны 1 орцны подвалын усыг шавхах ажлыг хийж гүйцэтгэлээ.

  

Даймонд хотхон 107р байр 1,2р орц дотор болон гадна шилэн хаалга угааж цэвэрлэсэн.

  

Нийтийн эзэмшлийн ороон сууцнуудын гадна талбайн шарилж ургамалын устгах, цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Жаргалант, 27а,б,в, 36а,б, 48, 52, 6, 8, 12 айлын гадна талын шарилж ургамал, Ногоон хотхон 5 байр, Даймонд хотхон 4 байр, Саруул хотхон 5 байр, Цайрт хотхон 3 байр, Мандал хотхон 12 байр, Цэлмэг хотхоны 3 байр, Дөрвөлж хотхон 4 байр, Залуус хотхоны 5 байрны гадна орчмын нийт 10 хотхоны 56 байрны нийтийн талбайн шарилж, ургамал устгал хийгдлээ.

   



Орцны хана, хаалга, шат, шатны бариул, цонх, цонхны тавцан угааж, цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Даймонд хотхоны 2 орц, Цэлмэг хотхоны 1, 2-р байрны 2 орц, Мандал хотхоны 2 байрны 2 орц, МХГ-ын 16 айл, 1 орц, нийт 7 орцны хана, хаалга, шат шатны бариулын хир буртаг, халтарыг угааж цэвэрлэх, шатлны бохь халтарыг арилгах ажлыг хийж гүйцэтгэлээ.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН: А.ӨЛЗИЙЖАРГАЛ

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн А/227 тоот захирамжаар цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд гарсан ажлын хэсэг-6 удирдах ажилтан-2, жолооч, малын эмч-8, туслах ажилтан-6, нийт-22 хүний бүрэлдэхүүнтэй гарч ажиллаж байна. Сумын хэмжээний хурга-100 толгой малд, цэцэг өвчний дархлаажуулалтад хамруулахаар Мал эмнэлгийн газраас цэцгийн вакцин-100.0 мян/тун хүлээн авч, ААН-6 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгч ажиллалаа.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын явцын мэдээгээр өрх-129, хурга-17512 толгой малд вакцин хийгдэж байна.

08 сарын 23-нд Төл малыг бруцеллёз өвчнөөс урьдчилан вакцин Штам-19,10.5 мян/тун, Рев-1,126.2 мян/тун вакцин болон галзуугийн вакцин-11,0 мян/тун авч, ДХХ - энтериобактериоз хам вакцин-231.0 л авч, МЭГазраас татан авч, ААН-ийн 6 мал эмнэлэгт хуваариалан өгч ажилласан.

Дуут хавдрын вакцин-47.4 л авч, үхэр-3055 толгой малд, листериозийн вакцин-140 л авч, хонь-13300, ямаа-5143 нийт-18443 толгой малд, цусан халдвартын вакцин-290.4л авч, хонь-7744, ямаа-5173 нийт-12917 толгой малд, бүгд-34415 толгой малд төлөвлөгөөт орон нутгийн вакцинжуулалтыг хийн гүйцэтгэж байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд: Угаалганд үхэр-995, хонь-17029, ямаа-9805 нийт-27829, туулгалтад хонь-8525, ямаа-6532 адуу-120, нийт-15177, боловсруулалтад хонь-12439, ямаа-5857, гуурын боловсруулалтад үхэр-1200 нийт-19496, бүгд-62502 толгой мал хамрагдаад байна.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 2023 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн сумын Засаг даргын А/ 118 тоот захирамжийн дагуу 4-н групп, гарч 04 дүгээр сарын 26 -наас 07 дүгээр сарын 30-ны хүртэл малын эмч, туслах ажилчин, жолооч, 12-н хүний бүрэлдэхүүнтэй тарилгыг хийж гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн газраас цэцгийн вакцин-43631мян/тун хүлээн авч, ААН-ийн 4 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгч ажилласан.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хот айл- 99, хонь-35729 хурга-9784, нийт- 45513 толгой малд тарилгыг хийж ажиллалаа.

Тарилгын зарцуулалтад вакцин-43513мт, хэвийн хорогдол-118, зарцуулан-43513 л, хонь-35729, хурга-9784, нийт- 45513 толгой малд вакциныг хийж гүйцэтгэн нэгтгэн МЭГазарт өгч ажилласан.

Малын эмч нараас тарилгын хоосон шил- 97ш, хүлээн авч МЭГазарт тушаан, өгч ажилласан.

Вакцинжуулалтын явцын мэдээ болон шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга, туулгалт, боловсруулалтын мэдээ, судалгааг Мал эмнэлгийн газарт өдөр бүр өгч ажиллалаа.

Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтад нийт-30 малчин өрхөөс судалгааг авч, ажилласан.

Амьд мал, махны гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулан ажиллалаа.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд ААН-ийн тус бүрээр нь малчин өрхүүдийн нэрсийг цахимд оруулан ажилласан.

Алтан-Овооны 110-н жилийн ой баярт хурдан морины уралдааны морины комисст Улсын байцаагч А.Доржсүрэн 3 хоног ажилласан

Махны нийлүүлэлтийн тогтвортой,уян хатан хөгжүүлэх,чадавхыг сайжруулах сэдэвт сурггалт хотод Улсын байцаагч 3 хоног суусан.

Байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцож ирлээ.